



“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2026 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

“Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурал 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн 10:00 цагт Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө, Blue sky tower, 3 давхар, Toraz HALL танхимд хуралдав.

Хурал даргалагч: “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Зоригтбат

Хурлаар хэлэлцсэн асуудал:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;
3. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга;
4. Компанийн өрийг хувьцаагаар солих тухай;
5. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай;
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

Хуралд оролцсон:

Компанийн төрийн эзэмшлийн хувьцааны 90 хувийг төлөөлж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Зоригтбат, Хууль, хүний нөөцийн газрын Хууль, эрх зүйн хэлтсийн менежер Ж.Чимэдцэрэн (саналын эрхтэй) нар оролцов.

Хуралд оролцсон бусад:

Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц.Төгсбуян, ТУЗ-ийн гишүүн, Нэр дэвшүүлэх хорооны дарга Л.Наранчимэг, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга С.Солонго нар оролцлоо.

Хурлаар хэлэлцсэн нь:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай;

Шийдвэрлэсэн нь:

Тооллогын комиссын дарга Э.Мандахнаран:

Тооллогын комисс 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийг танилцуулъя. “Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 13,419,101 ширхэг хувьцааг эзэмшдэг 1,596 хувьцаа эзэмшигч үнэт цаасны бүртгэл хөтлөх байгууллагад бүртгэгдсэн бөгөөд БДК-уудаас хуралд оруулах санал ирүүлээгүй. Төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэгч “Эрдэнэс Монгол” ХХК 90% буюу 12,077,191 хувьцаатай ирсэн байна. Бусад хувьцаа эзэмшигчдийг төлөөлж 12 хүн итгэмжлэлээр, 54 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр ирж, нийт ирсэн хувьцаа эзэмшигчдийн хувьцааны тоо 13,252,300 ширхэг хувьцаатай 65 хувьцаа эзэмшигчид хуралд оролцож, хурлын ирц 98.8 хувьтай байна. Компанийн тухай хуулийн 69.1-д “Компанийн саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш

хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно.” гэж заасан бөгөөд нийт хувьцаа эзэмшигчдийн хурлын ирц 98.8 хувьтай ирсэн учраас хурал хүчин төгөлдөр болохыг хурал даргалагч “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Зоригтбатад танилцуулж байна. Баярлалаа.

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Шивээ-Овоо” ХК-ийн 2026 оны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эхэлснийг мэдэгдье. Та бүхэнд “Шивээ-Овоо” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааны 90 хувийг төлөөлж, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Гүйцэтгэх захирлын тушаалыг танилцуулъя.

“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 04 сарын 28 өдөр

№ А/75

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцуулах тухай

Компанийн тухай хуулийн 68 дугаар зүйлийн 68.1, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн дүрмийн 3.3.6, 3.5.4, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөлөл хэрэгжүүлэх журмын 2.1.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хуралд “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Зоригтбат, Хууль, хүний нөөцийн газрын Хууль, эрх зүйн хэлтсийн менежер Ж.Чимэдцэрэн (саналын эрхтэй) нарыг тус тус томилон оролцуулсугай.

2.“Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурлыг зохих журмын дагуу даргалахыг Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Зоригтбатад даалгасугай.

3.“Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хуралд баримтлах удирдамжийг хавсралтаар баталсугай.

4.Хувьцаа эзэмшигчдийн хурлын бэлтгэл ажлыг хангаж, хурлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулахыг “Шивээ-Овоо” ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Батсуурьд үүрэг болгосугай.

5.Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон талаарх тайланг 2026 оны 5 дугаар сард багтаан тайлагнахыг Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Зоригтбатад үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Б.ДАВААДАЛАЙ

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэнэ.
Үүнд:

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
2. Компанийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай;
3. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийг танилцуулах;
4. Компанийн өрийг хувьцаагаар солих тухай;
5. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай;
6. Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны тайлан танилцуулах;
7. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай.

Хурал эхлэхээс өмнө Төлөөлөн удирдах зөвлөлөөс баталсан хурлын дэгийг танилцуулъя.

Хурал даргалагч Хурлын үйл ажиллагааг нээж, хэлэлцэх асуудал, хурлын дэгийг танилцуулна. Хэлэлцэх асуудлын дарааллын дагуу танилцуулж, хэлэлцэнэ. Энэ нь тус бүр 30

минут байна. Хуралд оролцогчдоос асуулт, хариултыг хүн тус бүрээр 3 минутад багтаан явуулна. Хуралд оролцогчдын санал, дүгнэлтийг хүн тус бүрээр 3 минут, завсарлага 20 минут, тооллогын комиссын тогтоолыг танилцуулах 5 минут, хурлаас гарах шийдвэрийн төслийг танилцуулж, батлуулах асуудал тус бүрээр 15 минут, хурлын үйл ажиллагааг хаах 5 минут байна. Та бүхэн хуралдааныхаа дэгийг хүлээн зөвшөөрч байна уу?

Хувьцаа эзэмшигчид:

Зөвшөөрч байна.

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

“Шивээ-Овоо” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг Гүйцэтгэх захирал Г.Батсуурь танилцуулна.

Гүйцэтгэх захирал Г.Батсуурь:

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсын эрчим хүчний салбарын тогтвортой үйл ажиллагааг тасралтгүй 36 жил ханган ажилласан, стратегийн чухал ач холбогдолтой уурхай юм. Миний бие уурхайн 7 дахь гүйцэтгэх захирлаар томилогдоод 6 сар орчим ажиллаж байна. Өнөөдөр хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид, “Эрдэнэс Монгол” ХХК-ийн удирдлагууд болон зочид, төлөөлөгчид та бүхэнд хүрэлцэн ирсэнд баярлалаа. Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудалд идэвхтэй оролцохыг та бүхэндээ уриалж байна.

Эрдэнэс Монгол нэгдлийн охин компани болох “Шивээ-Овоо” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулахад бэлэн боллоо. Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний орд нь Улаанбаатар хотоос зүүн, урагшаа 260км-т, Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын нутагт Улаанбаатар Бээжингийн олон улсын төмөр замын дэргэд, далайн түвшнээс 1,180-1,230 метрт оршдог бөгөөд орд нь шинэ ус, эхийн цагаан, ногоон тойрон гэсэн 3 хэсгээс бүрдэнэ. “Шивээ-Овоо” ХК нь Шинэ усны хэсэгт орших Эрдэнэс Монгол нэгдлийн нийт 4.290 га талбайд олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. Нүүрсний үлдэгдэл нөөц 587.8 сая тонн. Шивээ-Овоогийн хүрэн нүүрсний уурхай нь Монгол Улсын дотоодын цахилгаан, дулааны эрчим хүч үйлдвэрлэлийн нүүрсний нийт хэрэгцээний 21,7%-ийг хангадаг, стратегийн ач холбогдол бүхий хүрэн нүүрсний уурхай юм.

“Шивээ-Овоо” ХК нь Төвийн бүсийн цахилгаан, эрчим хүчний 58,7%, Улаанбаатар хотын дулааны эрчим хүчний 55,1%-ийг үйлдвэрлэдэг, ДЦС 4 ТӨХК-ийн нүүрсний хэрэгцээний 50%, Улаанбаатар хотын Зүүн бүсийн дулааны эрчим хүчийг үйлдвэрлэдэг Амгалан дулааны станцын нүүрсний хэрэгцээний 60%-ийг тус тус ханган нийлүүлдэг. Мөн орон нутгийн дулааны эрчим хүч үйлдвэрлэгч ААН байгууллагуудыг эрчим хүчний зориулалттай хүрэн нүүрсээр тасралтгүй ханган ажиллаж байна. Шивээ-Овоогийн уурхай жилдээ дунджаар 8.6 сая м3 хөрс хуулж, 2 сая тонн нүүрс олборлон борлуулах техникийн болон хүний нөөцийн хүчин чадалтай болно. 2021 оноос эхлэн хэрэглэгч нарын хэрэгцээнд нийцүүлэн өөрийн хүчин чадлыг давуулан ажиллаж байгаа бөгөөд 2024 онд хамгийн их буюу 2 сая 633 мянган тонн нүүрс олборлож, 31%-аар давуулан биелүүлж ажилласан. Компанийн нийт хувьцааны 90%-ийг Монгол Улсын Засгийн газар, 10%-ийг бусад хувьцаа эзэмшигчид эзэмшдэг. Монгол Улсын Засгийн газрын 2013 оны 100 дугаар тогтоолоор “Эрдэнэс Монгол” ХХК нь “Шивээ-Овоо” ХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааны төрийн төлөөллийг хэрэгжүүлж байна. Үнэт цаас эзэмшигчдийн хураангуй судалгаагаар нийт 13,419,101 ширхэг үнэт цаасны 10% буюу 1,341,910 ширхэг хувьцааг 1,596 иргэн, хуулийн этгээд эзэмшдэг бол 90% нь “Эрдэнэс Монгол” ХХК нь 12,077,191 ширхэг үнэт цаасыг тус тус эзэмшдэг.

Компанийн бүтэц, хүний нөөцийн мэдээлэл:

2025 онд нийт 487 орон тоотой үйл ажиллагаа явуулахаар батлуулсан бөгөөд гүйцэтгэлээр 433 ажилтантай ажилласан. Үүнээс үндсэн үйлдвэрлэлийн ажилтан 404 буюу 93%, оффисын 29 буюу 7%, эмэгтэй 76 буюу 18%, эрэгтэй 357 буюу 82% байна. Нийт ажилтны 58.2% нь мэргэжлийн болон техникийн боловсролтой, 47.6% нь 34-45 насны ажилчид эзэлдэг бол 42.5% нь 0-4 жил ажилласан тоон үзүүлэлттэй байна.

Борлуулалт, үйлдвэрлэл, үйлчилгээ:

2025 оны уулын ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн тухайд 2025 онд 10 сая 800 мянган м3 хөрс хуулж, 2,500 мянган тонн нүүрс олборлож, 2 сая 415 мянган тонн нүүрс борлуулахаар төлөвлөсөн бөгөөд хөрс хуулалт 11,089.9 мянган м3 буюу 102,7%, нүүрс олборлолт 2 сая 464.2 мянган тонн буюу 98.6%, нүүрс борлуулалт 2 сая 428.7 мянган тонн буюу 100.6%, нийт уулын

цулаар 102%-ийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Сүүлийн жилүүдэд хэрэглэгч нар төлөвлөгөөнд туссан нүүрсний хэмжээг нэмэгдүүлж, борлуулалт өсөж байгаа боловч үүний улмаас хөрсний хоцрогдол нэмэгдэх, хоногийн вагон ачилтын хүчин чадал дутагдах, уулын технологийн горим зөрчигдөх зэрэг хүндрэлүүд үүсэж байна.

Техник тоног төхөөрөмжийн ашиглалтын байдал 2025 онд уурхайн баланст 56 нэгж үндсэн техник, тоног төхөөрөмж бүртгэлтэй байсан бөгөөд эвдрэл, саатал, засвараас шалтгаалан 44 техник, машин механизмыг ашиглан уулын ажлыг гүйцэтгэсэн. Техникийн хүчин чадал дутагдсан уулын ажилд түрээсийн техникүүдийг авч ашиглан, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зохион байгуулсан. 2025 онд төлөвлөгөөт уулын ажлыг гүйцэтгэсэн 56 ширхэг уул тээврийн машин техникүүдээс 28 ширхэг буюу 50% нь ашиглалтын норм хугацаа дууссан. Иймд ашиглаж байгаа бүтээмж өндөртэй, сервис сэлбэг олдоцтой техникүүдийн хүчин чадлыг нэмэгдүүлж, уурхайн парк шинэчлэлтийг үе шаттай хэрэгжүүлж, өнөөгийн хэрэглээний 2.5 сая тонн нүүрсийг олборлох нийт уулын ажилд шаардлагатай 67.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх зайлшгүй шаардлагатай байна. Ашиглалтын хугацаа дууссан, хэт олон жил ашигласан машин, механизмуудын эвдрэл, саатал ихсэж, уулын төлөвлөгөөт ажилд хүндрэл үүсгэж, компанийн үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлсэн.

Худалдан авах ажиллагаа:

Компани нь 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний 168 төрлийн бараа, материал, ажил үйлчилгээг нийт 87.7 тэрбум төгрөгөөр худалдан авахаар, мөн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөгөөр 41 төрлийн бараа ажил үйлчилгээг 38.7 тэрбум төгрөгөөр тус тус худалдан авахаар төлөвлөсөн. 2025 онд нэн шаардлагатай дизель түлш, тэсэлгээний материал, дугуй, техник, тоног төхөөрөмжийн сэлбэг, тос тосолгооны материал, ХАБЭА-н бараа материал, бусдаар гүйцэтгүүлэх ажилд нийт 68.9 тэрбум төгрөг зарцуулж, хөрөнгө санхүүгийн дутагдлын улмаас 18.8 тэрбум төгрөгийн худалдан авалт хийгдээгүй болно. Худалдан авалтыг зохион байгуулахдаа нээлттэй тендер шалгаруулалтад 59 удаа, харьцуулалтын тендер шалгаруулалтад 39 удаа тус тус төрийн өмчийн хөрөнгийн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах тухай хуулийн дагуу ил тод нээлттэй зохион байгуулж ажилласан. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу гидро экскаватор кат 350-1 ширхэг, Ли Ти Эл Эйч 138, 90 тонны авто сноул-2 ширхэг, Жи Ар 3005 ти автрэйдэр-1 ширхэг, Эл Жи Эм Жи брэндийн Эм Эс 40 Эйч Эф 200 2 509 маркийн усны машин-1 ширхэг, Вазо фургон тэсэлгээний автомашин-1 ширхгийг тус тус худалдан авсан.

Компанийн санхүү эдийн засгийн үндсэн үзүүлэлт:

2025 онд 2 сая 428.7 мянган тонн нүүрс борлуулж, нүүрс борлуулалтын төлөвлөгөөгөө 100.6% буюу 13.7 мянган тонноор илүү гүйцэтгэсэн байна. 2025 онд борлуулалтаас 124 тэрбум 484.7 сая төгрөгийн орлого олохоор төлөвлөсөн бол гүйцэтгэлээр 125 тэрбум 706 сая төгрөгийн орлого олж, 101%-ийн гүйцэтгэлтэй гарсан. Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 695 дугаар тогтоолоор 1 тонн нүүрсний үнийг 53,197 төгрөгөөр баталсан ч 2025 оны 168 дугаар тогтоолоор 50,537 төгрөг болон 5%-аар бууруулсан.

Хуримтлагдсан өр төлбөрийн тухай:

Олон жил хуримтлагдсан өрийн талаар Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 157 дугаар тогтоол Засгийн газрын 2025 оны 27, 28, 30 дугаар тэмдэглэлийн дагуу ТУЗ-ийн 2025 оны 25, 26 дугаар тогтоолыг батлуулан "Шивээ-Овоо" ХК-ийн Японы олон улсын хамтын ажиллагааны банк, олон улсын хөгжлийн ассоциацийн санхүүжилтээр Сангийн ямаар дамжуулан зээлдсэн Монпи-4, Монпи-5 зээлийн өрийн үлдэгдэл 80.2 тэрбум төгрөг, татварын хуримтлагдсан өр төлбөр 20.3 тэрбум төгрөг, нийт 100.5 тэрбум төгрөгийн урт хугацаат өр төлбөрийг барагдуулсан.

НДШ-ийн өрийн талаар:

Аймгийн Нийгмийн даатгалын газартай харилцан зөвшилцөж, НДШ-ийн олон жилийн хуримтлагдсан 6.1 тэрбум төгрөгийн өрийг барагдуулахаар гэрээ байгуулан ажиллаж байна. Татвар төлөлтийн талаар 2020-2024 онуудад нийтдээ 16.1 тэрбум төгрөгийн татвар төлж байсан бол зөвхөн 2025 онд улсын төсөвт 20.1 тэрбум төгрөг, орон нутгийн төсөвт 5.5 тэрбум төгрөг, нийт 25.6 тэрбум төгрөгийн татвар төвлөрүүлсэн.

2025 оны нүүрс борлуулалтын төлөвлөгөө 101%-ийн гүйцэтгэлтэй биелсэн бөгөөд 125 тэрбум 706.6 сая төгрөгийн орлогын биелэлтийг харуулбал нүүрсний үнийн өөрчлөлтийн судалгаа, Эрчим хүчний зохицуулах хорооноос тогтоосон нүүрсний үнэ "Багануур" ХК-д 51,386 төгрөг буюу зөрүү 849 төгрөг, "Шарын гол" ХК 61,859 төгрөг буюу зөрүү 11,322 төгрөг байна.

Онцлох үйл явдал:

- ✓ Олон улсын ЖОРК стандартад нийцсэн хайгуулын өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэсэн;

- ✓ ХАБЭА-н 2025 онд гарч болзошгүй аваар, саатлаас урьдчилан сэргийлж, ХАБ-н чиглэлээр хийгдсэн төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус үзлэг зохион байгуулсан;
- ✓ Удирдлагын тогтолцооны стандартыг байнга сайжруулахад ISO: 450012018 стандартыг нэвтрүүлэх зорилгоор 50 анхан шатны бичиг баримт бүрдүүлэлтийг хийж, итгэмжлэгдсэн байгууллага, сургагч багш нараас чиглэл авч, тухайн стандарт нэвтрүүлэлт 80%-ийн гүйцэтгэлтэй байна;
- ✓ Эрсдэлийн үнэлгээ, эрсдэл өндөртэй 20 ажлын байранд дахин эрсдэлийн үнэлгээ хийж, эрсдэлийг бууруулах болон давтан сургалт хийх ажлыг зохион байгуулсан;
- ✓ Үйлдвэрлэлийн осол, зөрчил 2025 онд уурхайн хэмжээнд үйлдвэрлэлийн осол-1, осолд дөхсөн тохиолдол-4 гарч, ХАБ-н 135 зөрчлийг арилгаж ажилласан;
- ✓ Байгаль орчин, нөхөн сэргээлт 2025 онд нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөгөөний дагуу 5, 6 сард нөхөн сэргээлтийн гэрээт ажилтнуудаар ашиглалт явагдсан 3 мянган га газарт MNS:59152008, MNS:59162008, MNS:59172008, MNS:59182008 стандартуудын дагуу олон наст ургамлын үеэр биологийн нөхөн сэргээлт хийлгэж, график гарган усалгаа хийлгэсэн;
- ✓ Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг Эрдэнэс Монгол нэгдэл нь Ерөнхийлөгчийн Тамгын газартай 209 тоот хамтын ажиллагааны тухайд дэмжин, үүрэг амлалт авч, энэ хүрээнд Шинэ Хархорум хотын төлөвлөлтөд тусгагдсан ногоон байгууламж, ойн зурвас байгуулах зорилгоор нэгдлийн хэмжээнд 535 мянган ширхэг мод тарихаас, "Шивээ-Овоо" ХК 10 мянган ширхэг мод тарих амлалт авсан. Тус ажлын хүрээнд "Шивээ-Овоо" ХК-аас 818 сая төгрөгийн үнийн дүнтэй тендерт зарлаж, 10 мянган ширхэг мод тарих компанийг сонгон шалгаруулж, "Шивээ-Овоо" ХК 25/56 дугаартай гэрээ байгуулж, хамтран ажиллаж байна. Гэрээний дагуу хаврын тариалалт төлөвлөгдсөн 4 буюу 18.8 газар га газарт 2025 оны 5 дугаар сарын 27-ны өдрөөс 2025 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн хооронд хийгдсэн ба гүйцэтгэлээр 11,199 ширхэг мод тарьсан;
- ✓ Монгол улсын ерөнхий сайд Г.Занданшатар өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд "Шивээ-Овоо" ХК-ийн уурхайд ажиллаж, өвөлжилтийн бэлтгэлийг сайтар базааж, цахилгаан, дулааны найдвартай байдлыг хангах, ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлж, гүйцэтгэлийн үнэлгээгээ 50 хүртэлх хувиар үе шаттайгаар нэмэгдүүлэхийг үүрэг болгов;
- ✓ Говьсүмбэр аймагт 660мвт-ын цахилгаан станц байгуулах төслийн хүрээнд санамж бичиг байгуулан, хөрөнгө оруулагч нартай уулзалт зохион байгууллаа. Төвийн бүс, зүүн бүс болон говийн бүсийн цахилгаан, эрчим хүчний өсөн нэмэгдэж буй хэрэглээг хангах, найдвартай эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилгоор БНСВУ-ын хөрөнгө оруулалттай Рокс Энержи группийн охин компани "Ар Эс Си Эн Жи" ХХК-ийн хэрэгжүүлж буй Говьсүмбэр аймгийн Шивээговь суманд Шивээ-Овоогийн нүүрсний уурхайг түшиглэн 660мвт-ын хүчин чадалтай цахилгаан станц байгуулах төслийн хөрөнгө оруулагчтай аймгийн удирдлагууд болон "Шивээ-Овоо" ХК-ийн Гүйцэтгэх захирал Г.Батсуурь болон холбогдох албаны хүмүүст төслийн хэрэгжүүлэх үе шат, үйл явцын талаар мэдээлэл солилцох уулзалт хийлээ;
- ✓ Жорк хайгуулын ажил нь 2024 онд 1 дүгээр үе шат, 2025 онд 2 дугаар үе шат, 2026 онд 3 дугаар үе шатын хайгуулын ажлыг тус тус хийж гүйцэтгэсэн. Дээрх ажлын хүрээнд Шивээ-Овоо ордын нөөцийг олон улсын Жорк стандартаар баталгаажуулан ордын нөөцийг 45%-аар нэмэгдүүлж, 828 сая тонн хүргэсэн ба уурхайн насжилтыг 100 жилээр буюу 260 сая тонноор нэмэгдүүлсэн;
- ✓ Хүний хөгжлийг дэмжих ажлын хүрээнд "Шивээ-Овоо" ХК нь 2025 оны бизнес төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу ажилтнуудын эрүүл уурхайчин хөтөлбөрийн хүрээнд тус уурхайд 10-аас дээш жил тогтвор суурьшилтай ажилласан нийт 173 ажилтнуудыг Асралт Мед эмнэлэгтэй хамтран, хавдрын эрт илрүүлгийн үзлэг, шинжилгээнд бүрэн хамруулсан;
- ✓ Бүтээн байгуулалтын их үйлсийг тасралтгүй үргэлжлүүлж, эх орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж буй "Шивээ-Овоо" ХК үүсгэн байгуулагдсаны түүхт 35 жилийн ойн баяраа тэмдэглэн өнгөрүүлээ;
- ✓ Эв нэгдэл, эрүүл мэнд, ур чадвар, бие бялдрын хөгжлийг дэмжих зорилгоор жил бүр зохион байгуулдаг спортын олон төрөлт тэмцээнийг нийт 7 төрлөөр зохион байгуулагдаж, компанийн хэсэг нэгжүүдийн 9 багийн 230 гаруй тамирчид өрсөлдөж, аваргуудаа шалгарууллаа;

- ✓ Компанийн түүхт 35 жилийн ойг тохиолдуулан нийт ажилтнуудын дунд уурхайчдын урлагийн их наадмыг 8 төрлөөр зохион байгуулж, аваргуудаа шалгарууллаа;
- ✓ Эрдэнэс Монгол нэгдлийн хэмжээнд жилийн үйл ажиллагааны үзүүлэлтээр 2023 онд өртөг зардлаа бууруулж, үр ашгаа нэмэгдүүлэн, удирдлагын манлайллыг сайн хэрэгжүүлж, компанийн эдийн засгийн үзүүлэлтийг сүүлийн 3 жилийн хугацаанд хамгийн өндөр түвшинд хүргэсэн амжилтаар Эрдэнэс Монгол нэгдлийн 2023 оны менежментийн үйлчилгээг сайн хэрэгжүүлэгч компаниар шалгарч, 100 сая төгрөгийн шагнал авсан бөгөөд энэхүү шагналын сангаараа фитнес, иогийн шинэ барилгыг бүтээн байгуулсан. Ажилтнуудын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, тэднийг спортоор хичээллэх бололцоог ханган, бие бялдрыг нь чийрэгжүүлэх, нийтийн биеийн тамирын арга хэмжээг дэмжих зорилгоор фитнес, иогийн танхимын тохижилтын ажлыг бүрэн хийж, ашиглалтад оруулсан;
- ✓ “Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчид компанийн үйлдвэрлэл, үйл ажиллагаатай танилцав;
- ✓ Уул, уурхайн салбарын ажилтнуудын дунд жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Эрч хүч-Эв нэгдэл уурхайчдын спортын их наадам 2025” тэмцээнд компанийн 40 гаруй тамирчид оролцож, цахим спорт буюу и-спорт, PUBG Мобайл тэмцээнд багаараа 3 дугаар байрт орж, хүрэл медалийн эзэд болсон амжилт гаргасан;
- ✓ Сургалт хөгжлийн төлөвлөгөөгөө 2025 онд нийт 5 зорилтын хүрээнд 198.2 сая төгрөг төлөвлөсөн бөгөөд жилийн эцсийн гүйцэтгэлээр 122.7 сая төгрөг буюу 61.9%-тай биелүүлсэн байна;
- ✓ Говьсүмбэр аймгийн Политехник коллежтой хамтран ажилтнуудын боловсролыг дэмжих зорилгоор ажлын байран дээр мэргэшүүлэх, мэдлэг олгох зорилгоор механикжсан тээврийн хэрэгсэл, механизмын засвар үйлчилгээ, уул уурхайн ашиглалтын технологич мэргэжлээр 1.5 жилээр дипломын боловсрол эзэмшүүлэхээр 2 ангид элсэлт авч, сурган хамтран ажиллаж байна.

Тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх санал:

- ✓ Техник, технологийн шинэчлэлт 2026 оны төлөвлөгөөт уулын ажлыг гүйцэтгэх 56 ширхэг уулын тээврийн машин, техникүүдээс 28 ширхэг буюу 50% нь ашиглалтын нормын хугацаа дууссан. Одоогийн 2.5 сая тонн нүүрсийг хэвийн олборлоход 2027 онд 67.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийх шаардлагатай;
- ✓ “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 162.4 тэрбум төгрөгийн зээлийн өглөгийг толгой компани, охин компани хооронд хөрөнгө оруулалт болгон шийдвэрлүүлэх;
- ✓ Ерөнхий газраас 2024 оны нүүрс олборлолтод агаарын бохирдлын төлбөр тооцож, 2.4 тэрбум төгрөгийн акт тавьсан. Уурхайд түшиглэсэн 660 мвт цахилгаан станц баригдах төсөлтэй холбоотой техник, эдийн засгийн үзүүлэлт жилд 7 сая тонн нүүрс олборлохоор хийлгэх шаардлага үүссэн. Техник, эдийн засгийн үзүүлэлт боловсруулж, батлуулах 300 сая төгрөгийн төсөв шийдвэрлүүлж, 2026 онд багтаан техник, эдийн засгийн үзүүлэлт хийлгэх ажлыг эхлүүлэх;
- ✓ Мөрдөгдөж байгаа 1 тонн нүүрсний үнэ 50,537 төгрөг байгаа нь олон жилийн хуримтлагдсан өрийн дарамт, эздийн өмчийн сөрөг дүнг бууруулах, төлбөрийн чадварыг сайжруулахад 1 тонн нүүрсний үнийг ашигтай ажиллах хэмжээнд тогтоох шаардлагатай;
- ✓ Өвлийн ачаалалтай саруудад вагон, халалт, өртөөний сэлгээнд хүндрэл үүсдэг болсон 21 дүгээр өртөөний төмөр замын өргөтгөл хийх, шатахууны агуулахын багтаамж бага, хуучирсан тул 700м3-ээс дээш багтаамжтай шинэ агуулах барих асуудлууд тус тус тулгамдаж байна.

Та бүхэнд 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцууллаа. Тайлантай холбоотой асуулт байвал хариулна. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулсан Гүйцэтгэх захирал Г.Батсуурьд баярлалаа. “Шивээ-Овоо” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулъя.

ТУЗ-ийн дарга Ц.Төгсбуян:

**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 26/07

Улаанбаатар хот

**Компанийн 2025 оны үйл ажиллагааны
тайланд дүгнэлт гаргах тухай**

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2, 96 дугаар зүйлийн 96.4, “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 3.4.2.7-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.“Шивээ-Овоо” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны үр дүнг “Хангалттай” гэж дүгнэж, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Батсуурь)-д даалгасугай.

2.Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайланг нийтэд хүргэх, мэдээлэх ажлыг зохион байгуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Батсуурь)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ТӨГСБУЯН

Хурлаар хэлэлцсэн нь:

2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай:

Шийдвэрлэсэн нь:

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

“Шивээ-Овоо” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг танилцуулсан баярлалаа. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараагийн асуудал компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх танилцуулгыг Ерөнхий нягтлан бодогч У.Занабазар танилцуулна.

Ерөнхий нягтлан бодогч У.Занабазар:

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Компанийн 2025 оны санхүүгийн тайлан аудитлагдсан тайланд ТУЗ-ийн гаргасан тогтоолыг танилцуулъя.

**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 26/08

Улаанбаатар хот

**Компанийн 2025 оны санхүүгийн тайланд
дүгнэлт гаргах тухай**

Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.11, 80 дугаар зүйлийн 80.2, 96 дугаар зүйлийн 96.4, “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 3.3 дугаар зүйлийн 3.4.2.7-д заасныг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Компанийн 2025 оны санхүүгийн тайланг “Сайжруулах шаардлагатай” гэж дүгнэж, Үндэсний аудитын газраас “Шивээ-Овоо” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангийн хамт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Батсуурь)-д даалгасугай.

2.Үндэсний аудитын газраас “Шивээ-Овоо” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, актыг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган ажиллаж, биелэлтийг заасан хугацаанд хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Г.Батсуурь)-д үүрэг болгосугай.

3.Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (С.Цолмон)-д даалгасугай.

ТУЗ-ийн тогтоолтой холбогдуулаад 2025 оны санхүүгийн аудитлагдсан тайлангийн талаар мэдээлэл өгье.

Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулгад дурдагдсанчлан Эрчим хүчний зохицуулах хорооны 2024 оны 695 дугаар тогтоолоор 1 тонн нүүрсний үнийг 53,197 төгрөгөөр баталсан ч 2025 оны 168 дугаар тогтоолоор 50,537 төгрөг болон 5%-аар бууруулсан. Гэвч бид 2025 онд 125.9 тэрбум төгрөгийн орлого олж, 123.6 тэрбумын төгрөгийн зардал гарган алдагдалгүй ажилласан.

Олон жил хуримтлагдсан өрийн талаар Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 157 дугаар тогтоол Засгийн газрын 2025 оны 27, 28, 30 дугаар тэмдэглэлийн дагуу ТУЗ-ийн 2025 оны 25, 26 дугаар тогтоолыг батлуулан “Шивээ-Овоо” ХК-ийн Японы олон улсын хамтын ажиллагааны банк, олон улсын хөгжлийн ассоциацийн санхүүжилтээр Сангийн яамаар дамжуулан зээлдсэн Монпи-4, Монпи-5 зээлийн өрийн үлдэгдэл 80.2 тэрбум төгрөг, татварын хуримтлагдсан өр төлбөр 20.3 тэрбум төгрөг, нийт 100.5 тэрбум төгрөгийн урт хугацаат өр төлбөрийг барагдуулсан. Урт хугацаат өр төлбөр нь богино хугацаат буюу нэг жилийн хугацаатай өр төлбөрөөр тайланд тусгагддаг болсон.

НДШ-ийн олон жилийн хуримтлагдсан 6.1 тэрбум төгрөгийн өртэй гарсан. Түүнчлэн аймгийн Нийгмийн даатгалын газартай харилцан зөвшилцөж, өрийг барагдуулахаар гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2026 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар 4.7 тэрбум төгрөг болж, нийт 1.4 тэрбум төгрөгөөр бууруулж ажилласан. Өмнөх жилүүдэд тодорхой хэмжээгээр төлдөг байсан ч энэ өр хэвийн дүнгээр тусгагдаж, эрсдэл дагуулж байна гэдэг байдлаар аудитын тайланд дурдагдсан. Үүнд нэлээд ач холбогдол өгч барагдуулах тал дээр ажиллаж, 2020-2024 онуудад нийтдээ 16.1 тэрбум төгрөгийн татвар төлж байсан байна.

2025 онд “Эрдэнэс Монгол” ХХК-аас урт хугацаат өр төлбөр, татварын өр төлбөрийг түргэн хугацаанд шийдвэрлэсэнтэй холбогдуулан нийт зөвхөн 2025 онд 25.6 тэрбум төгрөгийг улс, орон нутгийн төсөвт төлж барагдуулсан. Гэвч Үндэсний аудитын газраас санхүүгийн тайланд хийсэн тайланд “Хязгаарлалтай” дүгнэлт өгсөн.

Энэ нь олон жилийн хуримтлагдсан өр төлбөр, мөнгө, санхүүгийн боломж нөөцөөс шалтгаалан дутагдалтай байснаас шалтгаалан, өр төлбөрөө барагдуулаагүй, хөрс хуулалтын ажлуудаа хоцроосон гэдэг байдлаар өндөр дүнтэй зөрчил, зөвлөмжүүд өгөгдөн гол шалтгаан болсон.

Компани 119.9 тэрбум төгрөгийн хөрөнгөтэйгөөр балансын дүн гарсан. Гэвч богино хугацаат өр төлбөр 195 тэрбум болж нэмэгдсэн. Энэ нь түрүүн хэлсэнчлэн олон жилийн хуримтлагдсан өр төлбөрийг урт хугацаат өр төлбөр, өр төлбөрийг богино хугацаанд өр төлбөрт шилжүүлсэнтэй холбоотойгоор богино хугацаат өр төлбөр нэмэгдсэн. Урт хугацаат өр төлбөр 2024 оны жилийн эцсийн байдлаар 87.6 тэрбум төгрөг байсан бол 11.2 тэрбум төгрөг болж буурсан. Эсрэгээрээ урт хугацаат өр төлбөр буурсан буюу нийт 206.8 тэрбум төгрөгийн өртэй байна. Энэ өр нь нийт хөрөнгийн дүнгээс давсан. Үүнтэй холбоотой дараа дараагийн танилцуулгад танилцуулагдахаар байна.

Нийтдээ 125.6 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой, 1.8 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан. Энэ нь 2015 оноос хойш анх удаа компани ашигтай ажилласан тохиолдол болж байгаа бөгөөд олон жилийн хуримтлагдсан өр төлбөрийг тодорхой хэмжээнд богино хугацаанд шийдвэр гаргаж барагдуулсантай холбоотойгоор ашигтай ажиллах нэг талын эерэг үзүүлэлт болсон. Энэхүү хуримтлагдсан өр төлбөрийг энэ жилдээ багтаан, компанид эерэг байдлаар шийдвэр гарч, хэрэгжих бол цаашид өр төлбөр, хөрөнгө, мөнгөний асуудлаар хүндрэл учруулахгүйгээр илэрсэн зөрчлүүд тодорхой хэмжээнд буурах боломжтой.

Компанийн 2020-2025 оны санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдээр санхүүгийн шинжилгээг хийж гүйцэтгэсэн. Үүгээр өөрийн хөрөнгөөр нийт богино хугацаат өр төлбөрийг барагдуулах боломжийг тооцоолсон. 2025 оны байдлаар 147.5 тэрбум төгрөгийн алдагдал, 195.6 тэрбум төгрөгийн богино хугацаат өр төлбөртэй харагдаж байна. Гэтэл эргэлийн хөрөнгө 48 тэрбум төгрөг буюу эргэлтийн хөрөнгөөр богино хугацаат төлбөрөө барагдуулах боломж 48 тэрбум төгрөг ч гэсэн алдагдал 147 тэрбум төгрөг.

Түргэн хөрөнгийн харьцаа буюу түргэн хөрөнгөд мөнгөн хөрөнгө болон авлагыг оруулж тооцдог. Энэ түргэн хөрөнгөөр богино хугацаат өр төлбөрийн зөвхөн 10%-ийг л

барагдуулах боломжтой байна. Зохистой харьцаа нь 80%-аас дээш байдаг. Гэтэл компанийн хувьд хөрөнгө, мөнгөний боломж тааруугаас болоод энэ үзүүлэлт муу байна. Түргэн хөрөнгийн хэмжээ мөнгө, авлага нийлээд 20.5 тэрбум төгрөг байна. Өмнөх жилүүдэд мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эцсээр маш бага хэмжээнд үлддэг байсан. 2025 онд гэхэд 20.5 тэрбум төгрөгийн түргэн хөрвөх хөрөнгийн үлдэгдэлтэйгээр гарсан нь компани болон удирдлагуудын зүгээс тодорхой хэмжээний арга хэмжээ авч үлдсэн нөлөөлөл байна.

Эргэлтийн хөрөнгийн харьцаа буюу хөрөнгөө богино хугацаанд үр дүнтэй барагдуулах боломж 25% байна. Энэ үзүүлэлт 2 болон түүнээс дээш хэмжээнд байж зохистой харьцаа хангагдана.

Өр төлбөрийн хувийн жин нийт өр төлбөрийн 95% нь богино хугацаатай өр төлбөр болсон байна. Нэг жилийн хугацаатай. Ингээд төлбөрийн чадварын шинжилгээ хийж үзэхэд манай санхүүгийн тайлангийн ерөнхий үзүүлэлтүүд нэлээн асуудалтай, мөнгөн хөрөнгийн дутагдал маш их, өр төлбөр нэмэгдсэн байна гэдэг дүгнэлтэд хүрч болохоор байна. Графикаар харуулбал цэвэр эргэлтийн хөрөнгийн дүн -145.5 тэрбум болоод нэмэгдчихсэн. Түргэн хөрвөх хөрөнгийн харьцаа жил болгон нэмэгдээд явж байна.

Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ гээд бие даах чадварын коэффициент дээр эздийн өмч болоод нийт хөрөнгийг харьцуулахад мөн л -72 гэдэг дүн гарсан.

Санхүүгийн хамаарлын шинжилгээ мөн л -1.38, өр төлбөрийн хувийн жин 1.72 гээд хөрөнгөөс 172%-аар илүү өр төлбөртэй байна гэдэг үзүүлэлт байна.

Урт хугацаат зээл болон эздийн өмчийн харьцаа хасах утгатай. Нийт эздийн өмч хасах утгатай буюу олон жилийн хуримтлагдсан алдагдлуудаас шалтгаалаад 86 тэрбум төгрөгийн алдагдалтай болчихсон. Эдгээр үзүүлэлтүүдээр санхүүгийн тайланд шинжилгээ хийхэд эрүүл бус үзүүлэлтүүдийг гаргаж байна. Тэгэхээр энэ асуудлуудыг бид бүхэн богино хугацаанд шийдвэр гаргаж, олон жилийн хуримтлагдсан өр төлбөр, алдагдлуудыг барагдуулах талаар шийдвэр гаргаж ажиллахгүй энэ хэвээр байвал алдагдал өсөж, компанийн хэвийн үйл ажиллагаанд доголдол үүсэхээр байна.

Ашигт ажиллагааны шинжилгээ хийн, сүүлийн 10 жилд анх удаа 1.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. 2025 онд тодотгол хийхэд, орлого зарлагын дүн багахан хэмжээний буюу 30, 40 сая төгрөгийн ашигтай ажиллахаар тодотгол батлагдсан. Богино хугацаанд шийдвэр гаргаж, зардал тооцооллын анализ хийсний үр дүнд 1.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан байна. Гэвч ашгийн түвшинг 125 тэрбум төгрөгийн орлоготой харьцуулбал 1.4% байна. Үүнээс үзэхэд бид бүхэн богино хугацаанд энэ хуримтлагдсан өр төлбөрийг барагдуулах чиглэлээр шийдвэр гаргаж ажиллавал компанид ашигтай ажиллах нөхцөл бий болох юм гэж бид бүхэн харж байна.

Санхүүгийн аудитын тайлангаар нэлээд зөрчил гарсан. Үүнийг бид 2026 оноос эхлээд тодорхой хэмжээнд шийдвэрлэн ажиллаж байна. Тухайлбал түрүүн дурдсанчлан НДШ-ийн өр төлбөр, үүнийг барагдуулан ажиллаж байна. Мөн компанид ашиглагдахгүй техник, сэлбэгүүд бий. Үүнийг бид эргэлтэд оруулж ашиглах боломжтой бөгөөд өөр компанид ашиглах, эсхүл орлогын алдагдлыг нөхөх байдлаар алдагдлаа нөхөж, 14 сая орчим төгрөгийн акт тавигдсаныг бид энэ 4 сардаа багтаан төлж барагдуулсан. Компанийн зүгээс шийдвэрлэж болох зүйлсэд анализ, тооцооллыг хийн, шийдвэрлэж байгаа хэдий ч хөрөнгө, мөнгө, санхүүгийн дутагдлаас үүссэн зөрчлүүдийг бид бүхний хоорондын хамтын ажиллагааны үндсэнд шийдвэрлэх нөхцөл байдалтай байна.

Компанид санхүүгийн үзүүлэлтүүд сайжруулахын тулд хийгдэх 2 гол тулгамдаж буй асуудал байна. Үүнд:

1. Хуримтлагдсан өр төлбөр;
2. Нүүрсний үнэ өртөгтөө хүрдэггүй гэсэн ийм асуудал байдаг.

Эрчим хүчний зохицуулах хороогоор батлуулдаг. Эрчим хүчний зохицуулах хороонд бид удаа дараа хандаж, нүүрсний үнийг өртөгт нь хүргэх тухай хүсэлтийг хүргүүлсэн. Гэтэл хүссэн хэмжээгээр батлагддаггүй. Жил ирэх тусам инфляц нэмэгдэж, нүүрсний үнэ нэмэгддэггүй учраас борлуулалтын орлогоос алдагдал хүлээдэг. Хэрэв нүүрсний үнэ өртөгтөө хүрж нэмэгдвэл тодорхой хэмжээний ашигтай ажиллах хэмжээнд хүрэх боломжтой юм. Дараагийн танилцуулгаар нэлээн нарийвчлан мэдээлэл өгнө. Баярлалаа.

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Төлөөлөн удирдах зөвлөлөөс 2025 оны “Шивээ-Овоо” ХК-ийн санхүүгийн үйл ажиллагаанд гаргасан дүгнэлт болоод санхүүгийн тайлангийн талаар танилцуулсан Ерөнхий

нягтлан бодогч У.Занабаярт баярлалаа.

Хурлаар хэлэлцсэн нь:

3. Ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан шийдвэрийн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрийн танилцуулга:

Шийдвэрлэсэн нь:

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Дараагийн хэлэлцэх асуудал ногдол ашиг хуваарилах эсэх талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулъя.

Ерөнхий нягтлан бодогч У.Занабазар:

Та бүхэндээ ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн тогтоолыг танилцуулъя.

**“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 26/03

Улаанбаатар хот

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай

Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 47 дугаар зүйлийн 47.1.1 дэх заалт, “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 2 дугаар зүйлийн 2.2.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Шивээ-Овоо” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн дагуу ногдол ашиг төлсний дараа төлбөрийн чадвартай байх нөхцөлийг хангаагүй тул ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.

2. Энэ тогтоолыг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч (Г.Батсуурь)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ТӨГСБУЯН

Өмнөх жилүүдэд дандаа алдагдалтай ажиллаж байсан хэдий ч 2025 оны жилийн эцэст татварын өмнөх ашгаар 2.2 тэрбум төгрөг, татварын дараах ашгаар 1.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан. Мөнгөн хөрөнгө, авлага, бусад гээд хураангуйлсан тайлангаар эргэлтийн хөрөнгө 48.1 тэрбум төгрөг, эргэлтийн бус хөрөнгө буюу үндсэн хөрөнгө 71.8 тэрбум төгрөг гээд нийт хөрөнгө 119.9 тэрбум төгрөг байна.

Богино хугацаат өр төлбөр 195.6 тэрбум төгрөг, урт хугацаат өр төлбөр 11.2 тэрбум төгрөг, эздийн өмч хасах утгатай 86.9 тэрбум төгрөг гээд 119.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрт бол эздийн өмчийн бүртгэлтэй 86.9 тэрбум төгрөгийн алдагдал уурхай анх байгуулагдсанаас хойших алдагдлууд нэмэгдсээр 86.9 тэрбум төгрөгийн алдагдалтай болсон. 2024 оны жилийн эцэст 88 тэрбум төгрөг байсан бөгөөд энэ жилийн тодорхой хэмжээний ашгаар алдагдал 1.8 тэрбум төгрөгөөр буурсан.

Нийт борлуулалтын цэвэр орлого 125.7 тэрбум төгрөг, борлуулалтын цэвэр өртөг 112.2 тэрбум төгрөг гээд ерөнхий мэдээлэл байна.

Түрүүн танилцуулсан санхүүгийн тайланд хийсэн шинжилгээнүүдийг хураангуйлан танилцуулъя. Эргэлтийн харьцаа 25%-тай, төгрөгөөр өгөх харьцаа нь 11, бэлэн мөнгөний харьцаа 5 гээд өрийн дарамт нь хөрөнгөөс давчихсан буюу маш их өртэй байна. Өр ба өмчийн харьцаа, эздийн өмчийн харьцаа хасах утга руугаа орчихсон. Бэлэн мөнгөний санхүүгийн хүндрэлтэй байдалд орчихсон үзүүлэлтүүдийг харуулж байна. Үүнтэй холбогдуулан ногдол ашиг хуваарилахгүй байх талаар танилцуулъя.

Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1.1-д ногдол ашиг төлсний дараа компани нь төлбөрийн чадвартай байх гэж заасан байдаг. Энэхүү шаардлагыг компанийн 2025 оны санхүүгийн бодит үзүүлэлттэй уялдуулан үнэлэхэд төлбөрийн чадварын харьцаанууд хангалтгүй, эмзэг түвшинд байна. Эргэлтийн харьцаа 0.25, богино хугацаат өр төлбөрийг бүрэн хаах хэмжээний эргэлтийн хөрөнгө байхгүй. Түргэн хөрвөх чадварын харьцаа 0.11, бэлэн мөнгөний харьцаа 0.05 гээд богино хугацааны төлбөрийг шууд мөнгөн эх үүсвэрээр хангах

боломж, маш хязгаарлагдмал байна. Үүнтэй зэрэгцэн өрийн дарамтын харьцаа 1.72 байна. Нийт өр төлбөр, нийт хөрөнгөөс давсан эздийн өмчийн харьцааг -0,72 нь балансын бүтцийн хувьд сөрөг өмчтэй, техникийн төлбөрийн чадваргүй байдал үүссэнийг илтгэнэ. Мөн хүүгийн хамааралтай харьцаа 1.43 буюу ашиг хүүгийн зардлыг хязгаарлагдмал түвшинд хааж байгааг илэрхийлж байна. Эдгээр үзүүлэлтүүдийг харгалзан компанийн санхүүгийн байдал, төлбөрийн чадварын харьцаа хангалтгүй учраас ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн.

Цаашид 1 тонн нүүрсний борлуулах үнэ болоод олон жил хуримтлагдсан өр төлбөрийн асуудлуудыг шийдвэрлэснээр дараа, дараагийн жилүүдэд ашигтай ажиллах нөхцөл бүрдэж, ногдол ашиг хуваарилах талаар та бүхний эрх ашгийг хангах зүгээс анхаарч ажиллах болно гэдгийг Та бүхэнд нэмж хэлмээр байна. Баярлалаа.

Хурлаар хэлэлцсэн нь:

4. Компанийн өрийг хувьцаагаар солих;
5. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай:

Шийдвэрлэсэн нь:

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Баярлалаа. Дараагийн хэлэлцэх асуудал буюу өрийг хувьцаагаар солих, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах эсэх асуудлын талаар хоорондоо хамаарал бүхий асуудлууд учраас хамтад нь хэлэлцье.

Ерөнхий нягтлан бодогч У.Занабазар:

Өмнөх танилцуулгуудаар нэлээд дурдагдсан. Өр төлбөр маш өндөр, санхүүгийн баланс эрүүл бус асуудалтай байна. Энэ талаар та бүхэнд байнга танилцуулга, мэдээлэл хийгээд байгаа. Үүнтэй холбоотойгоор компанийн ТУЗ-өөс тогтоол гаргасан тогтоолыг танилцуулъя.

“ШИВЭЭ-ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 04 сарын 28 өдөр

Дугаар 26/09

Улаанбаатар хот

Компанийн өрийг хувьцаагаар солих
арга хэмжээний тухай

Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйл, 31 дүгээр зүйлийн 31.3, 75 дугаар зүйлийн 75.1, 80 дугаар зүйлийн 80.2, “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 157 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 27 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Эрдэнэс Монгол” ХХК-д төлөх нийт өрийг барагдуулах хүрээнд компанийн өрийг хувьцаагаар солих асуудлыг нарийвчлан судалж, холбогдох тооцооллыг хийн, төслийг хууль, дүрэм, журамд нийцүүлэн боловсруулахыг Гүйцэтгэх захирал (Г.Батсуурь)-д даалгасугай.

2. Компанийн өрийг хувьцаагаар солих арга хэмжээний талаар боловсруулсан төслийг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (Г.Батсуурь)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Ц.ТӨГСБУЯН

Компанийн өрийг хувьцаагаар солих энэ удаагийн танилцуулж буй асуудал нь хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл өгөх зорилгоор танилцуулж байна. Энэ удаагийн өрийг хувьцаагаар солих асуудлаар шийдвэр гарахгүй бөгөөд дараа дараагийн асуудлыг хамтран шийдвэрлэхийн тулд та бүхэнд ерөнхий мэдээлэл өгөх байдлаар танилцуулж байна.

Компанийн 2025 оны санхүүгийн тайлангаар нийт хөрөнгө 119.9 тэрбум төгрөг, нийт өр төлбөр 206.8 тэрбум төгрөг, эздийн өмч олон жилийн алдагдлаас шалтгаалаад 86.9 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.

Компанийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3-д “Тухайн жилийн санхүүгийн тайлангаар компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээсээ багассан тохиолдолд Төлөөлөн удирдах зөвлөлд нэн даруй мэдэгдэж, ХЭХ-ыг зарлаж, хувь

нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах, компанийг дахин хөрөнгөжүүлэх эсвэл татан буулгах асуудлыг шийдвэрлүүлэх үүрэгтэй” гэж заасан.

Компанийн 2025 оны санхүүгийн тайлангаар эздийн өмчийн дүн -86.9 тэрбум төгрөг хүрсэн учраас энэ мэдээллийг та бүхэнд танилцуулж, цаашид хэрхэн шийдвэрлэх талаар хамтын шийдвэр гаргая гэдэг байдлаар танилцуулж байна.

1.Үндэслэлүүд гэвэл богино хугацаанд өрийн өрийн дүн их хэмжээтэй мөн хүүтэй байгаа.

2.Өөрийн хэмжээ нийт хөрөнгөтэй харьцуулахад 1.7 дахин их болсон, түргэн хөрөнгө мөнгө буюу авлагаар 10%-ийн өр төлбөр барагдуулах хувь хэмжээ, мөнгөн хөрөнгийн хомсдол их, цаашид энэ хэвээр үргэлжилбэл алдагдал улам олширч, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө үнэгүйдэх эрсдэлтэй байна гэдэг тооцоонд хүрсэн байна.

Компани нийт 13,419,101 ширхэг хувьцаатай бөгөөд үүний 90%-ийг толгой компани эзэмшиж, бусад 10% буюу 1,341,901 ширхэг хувьцааг 1,596 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 157 дугаар тогтоолоор “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-ийн өр төлбөрийн талаар авах зарим арга хэмжээний тухай тогтоол гаргасан. Тус тогтоолоор 2 компанийн хуримтлагдсан өр төлбөр маш өндөр байгаа учраас хууль, журамд нийцүүлэн шийдвэрлэж ажиллахыг “Эрдэнэс Монгол” ХХК-д даалгасан. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 27 дугаар хурлын тэмдэглэлээр тогтоолоор “Багануур” ХК, “Шивээ-Овоо” ХК-аас “Эрдэнэс Монгол” ХХК-д төлөх нийт өрийг барагдуулах хүрээнд өрийг хувьцаагаар солих асуудлыг судалж тооцсоны үндсэн дээр зохих арга хэмжээг холбогдох хууль, тогтоомжийн дагуу авч, хэрэгжүүлэхийг “Эрдэнэс Монгол” ХХК-д даалгасан. Энэхүү ЗГ-ын шийдвэр, тогтоол гарсны дагуу асуудлыг судалж, та бүхэнд ерөнхий мэдээлэл өгөх зорилгоор танилцуулахаар бэлтгэлээ.

Өрийг хувьцаагаар солиход үнэ ханшийг хэдээр тогтоох, хэдий хэмжээний хувьцаа нэмж гаргах, жижиг хувьцаа эзэмшигч гэж нэрлэдэг 10%-ийн хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг алдагдуулахгүй байдлаар байх боломжтой байдлаар тооцоо хийж байгаа. Өнөөдрийн байдлаар сүүлийн 6 сарын нэрлэсэн дундаж үнэ, хувьцааны ханш 3,024 төгрөг байна. Энэхүү хувьцааны үнэлгээг СЗХ, хөрөнгийн биржид бүртгэлтэй, мэргэжлийн үнэлгээний брокер, дилерийн компаниас зөвлөгөө, зөвлөмж авсны үндсэнд дараагийн хурлаар нарийвчилсан тооцоололтойгоор танилцуулъя гэсэн байдлаар тооцож байна.

Үүнтэй холбогдуулан хэрэв бид бүхэн өр төлбөрийг барагдуулчихвал цаашид компани ашигтай ажиллахад нэлээн ахицтай, үр дүнтэй үзүүлэлтүүд гарах юм. Тухайлбал, зээлийн хүүгийн дарамт буурна, зээл төлөх байсан мөнгөн хөрөнгийг бусад үйл ажиллагаанд зарцуулах боломжтой болно, санхүүгийн аудитаар энэ талаар зөвлөмж, зөрчил ирүүлсэн. Үүнтэй холбоотойгоор санхүүгийн аудитаар өгсөн зөвлөмж биелнэ, өр төлбөр болон активын зохистой харьцаа хангагдана. Цаашид үйл ажиллагаа жигдэрснээс хувьцааны ханш өсөх, хөрөнгийн биржээр дамжуулан хөрөнгө оруулалт татах, бусад хямд санхүүгийн эх үүсвэрийг харьцуулан судалж, сонголт хийх боломж нэмэгдэнэ.

Компани алдагдалтай, өр нь хөрөнгөөсөө давчихсан учраас хямд, муу эх үүсвэрийг хайх, хөрөнгийн биржээс хөрөнгө оруулалт татах боломж байхгүй. Ийм алдагдалтай компанид хөрөнгө оруулах газар, компани байхгүй учраас эхний ээлжид балансыг цэвэрлэж, эрүүлжүүлээд авъя. Тэгээд дараагийн хөрөнгө оруулалт татах, хөрөнгө бий болгох асуудал дээр дараагийн арга хэмжээнүүдийг аваад явахад боломж бий гэдэг эерэг дүгнэлтэд хүрсэн.

Үүнтэй холбогдуулаад бид бүхэн цаашид СЗХ, Монголын хөрөнгийн биржийн тусгай зөвшөөрөл бүхий компаниас зөвлөгөө авах, нэмж гаргах хувьцааны тоо, ширхэг, нэгж үнийн дүнг эцэслэн тодорхойлох, зээлдүүлэгч компаниас өрийг хувьцаанд шилжүүлэх зөвшөөрөл хүсэх, СЗХ МХБ-д бүртгүүлэх материалыг яаралтай бэлтгэх, ХЭХ-аар хэлэлцүүлэн шийдвэр гаргуулах, хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг ноцтойгоор хөндөхгүй байх, өрийг хувьцаанд шилжүүлэх тухай хууль, тогтоомжид заасны дагуу судалж, тооцоолон хамгийн оновчтойг сонгон, ХЭХ-ыг дахин зарлаж, энэ асуудлыг шийдвэрлүүлэхээр танилцуулах гэсэн төлөвлөгөөтэйгөөр ажиллаж байна.

Энэ талаар МХБ болон СЗХ-ны төлөөллүүдтэй хоорондын уулзалт, хэлэлцээрүүдийг хийж байна. Өнөөдрийн танилцуулгаар бид бүхэн дахин судалгаа хийгээд та бүхэнд эргэж танилцуулж, шийдвэрлүүлэх боломжтой гэдэг байдлаар танилцууллаа. Тийм учраас дүрмийн өөрчлөлтийн асуудлыг хэлэлцэх боломжгүй боллоо. Баярлалаа.

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Компанийн өрийг хувьцаагаар солих, компанийн дүрэмд өөрчлөлт оруулах асуудлаар хийгдэж буй ажил болоод цаашдын хийх шаардлагатай ажлуудын талаар товч мэдээлэл өгсөн компанийн удирдлагуудад баярлалаа.

Хурлаар хэлэлцсэн нь:

6. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга:

Шийдвэрлэсэн нь:

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг ТУЗ-ийн дарга Ц.Төгсбуяныг танилцуулга хийхийг урьж байна.

ТУЗ-ийн дарга Ц.Төгсбуян:

Өнөөдрийн ХЭХ-д хүрэлцэн ирсэн та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу та бүхэнд “Шивээ-Овоо” ХК-ийн ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулъя.

Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн тухай хуульд заасны дагуу аудитын хороо, цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороо гэсэн 3 хорооны бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа явуулдаг. Нийт 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд үүнээс 6 гишүүн нь төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүнээр, хараат бус 3 гишүүний бүрэлдэхүүнтэй. Дэлгэцэд харагдаж байгаачлан төрийн төлөөллийг хэрэгжүүлэгч гишүүд ЭХЯ, АҮЭБЯ, ЗГХЭГ, ЭЗХЯ, болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн төлөөллүүд ТУЗ-ийн бүрэлдэхүүнд орж ажилласан.

Бид компанийн стратеги, бизнес төлөвлөгөө, бодлогыг батлах, мөн гүйцэтгэх удирдлагыг томилох, үндсэн бодлого, дүрэм, журмуудыг батлах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих, гүйцэтгэлийг хянах, аудитын хяналтыг хэрэгжүүлэх, удирдлагын тогтолцоог хэрэгжүүлэх, мөн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх үндсэн чиг үүрэгтэй үйл ажиллагаагаа явуулдаг. Өнгөрсөн оны хугацаанд ТУЗ нийт 10 удаагийн хурлыг зохион байгуулж, нийт 28 тогтоол, 30 тэмдэглэлийг гаргаж баталсан байна. Мөн компанийн ашигтай ажиллагааг нэмэгдүүлэх, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр холбогдох зөвлөмж, үүрэг даалгавруудыг компанийн гүйцэтгэх удирдлагуудад өгч ажилласан.

Та бүхэнд тогтоол, тэмдэглэлийн хэрэгжилтийн мэдээллийг сүүлийн 2 жилийн байдлаар харьцуулан харуулсан байна. 2024 онд нийт 17 тогтоол бүрэн хэрэгжээд, 5 тогтоол хэрэгжих шатанд буюу нийт 94.5%-ийн хэрэгжилттэй байсан бол 2025 онд нийт 28 тогтоол бүрэн хэрэгжиж, 1 тогтоол хэрэгжилтийн шатад буюу хэрэгжилтийн хувь 99.3%-тай байна. Мөн ТУЗ-ийн засаглалын тайлан болон засаглалтай холбоотой мэдээллийг та бүхэнд сүүлийн 3 жилээр харуулж байна. СЗХ-ны болон МХБ-д бүртгэлтэй 113 нээлттэй ХК-ийн засаглалын кодексын тайлангийн 2025 оны эхний хагас жилийн байдлаар баталгаажуулсан хэрэгжилтийн үнэлгээгээр 93.1% үнэлгээгээр буюу нийт 113 компаниасаа 5 дугаар байранд жагссан. Засаглалын үнэлгээ жилээс жилд та бүхэн нэмэгдэж байгааг доод талын хувиас харж болно. 2023 онд 64%, 2024 онд 92% болж маш огцом сайн өссөн, 2025 онд 93% болж үе шаттайгаар засаглалын үнэлгээ нэмэгдэж байна. “Шивээ-Овоо” ХК-ийн засаглалын үнэлгээ засаглал сайн буюу эрсдэлгүй түвшинд үйл ажиллагаагаа явуулж байна. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг товч танилцууллаа.

Бид компанийг ашигтай ажиллуулах, ногдол ашиг тогтвортой хуваарилдаг байх тал дээр тодорхой бодлого хэрэгжүүлэн ажиллаж байна. Хэдийгээр нүүрсний үнийг чөлөөлөөгүйгээс шалтгаалаад бид өртгөөрөө нүүрс борлуулах боломжгүй хэдий ч компанийн удирдлагаас танилцуулсанчлан уурхайн дэргэд цаашид тухайн нүүрсээ ашиглаад бүтээгдэхүүн үйлдвэрлэх, цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, цахилгаан станцдаа арай нэмүү өртөг шингээж, ашигтайгаар бүтээгдэхүүнээ борлуулах байдлаар ашигт ажиллагаагаа нэмэгдүүлэх чиглэлээр компанийн удирдлага өнгөрсөн онд тодорхой ажлуудыг амжилттай гүйцэтгэсэн. Хэрэв бид 660 мвт-ын цахилгаан станц ашиглалтад орж, төвийн эрчим хүчээр эрчим хүчний системд нийлүүлж эхлэх юм бол Монгол Улсад тулгараад буй цахилгаан эрчим хүчний хомсдолыг нөхнө, цаашид компани ашигтай ажиллаж, хувьцаа эзэмшигч та бүхнийг ногдол ашиг авах боломжийг бүрдүүлэхээр “Шивээ-Овоо” ХК болон “Эрдэнэс Монгол” ХХК-ийн зүгээс тодорхой арга хэмжээнүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлж байгааг дуулгахад таатай байна. Баярлалаа.

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

ТУЗ-ийн 2025 оны үйл ажиллагааны тайланг танилцуулсанд баярлалаа.

Хурлаар хэлэлцсэн нь:

7. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай:

Шийдвэрлэсэн нь:

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөний дагуу дараагийн асуудлыг хэлэлцье. “Шивээ-Овоо” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга Л.Наранчимэг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтын тайланг танилцуулъя.

ТУЗ-ийн гишүүн, НДХ-ны дарга Л.Наранчимэг:

Эрхэм хувьцаа эзэмшигчид, хуралд оролцож буй та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. “Шивээ-Овоо” ХК-ийн ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны дарга Л.Наранчимэг миний бие сонгон шалгаруулалтын тайланг танилцуулах гэж байна.

Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн “Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус 3 гишүүний сонгон шалгаруулалтыг нийтэд нээлттэй зарласан.

“Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдрийн 26/06 дугаар тогтоолоор “Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий түр хороог байгуулж, Нэр дэвшүүлэх хорооны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчийг бүртгэн сонгон шалгаруулалт хийж, хувьцаа эзэмшигчдийн хуралд нэр дэвшүүлэх чиг үүргийг шилжүүлсэн болно.

“Шивээ-Овоо” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах үүрэг бүхий түр хороо 2026 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 75 дугаар зүйлийн 75.4, 81 дүгээр зүйлийн 81.1, 81.5 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 85 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчит компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах нийтлэг журам”-ыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнд нэр дэвшигчид тавих шаардлагыг тодорхойлж, ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлага зэргийг тодорхойлон сонгон шалгаруулалтын зарыг хэлэлцэж баталсан.

Хараат бус гишүүний сонгон шалгаруулалтын зарыг 2025 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр нийтийн мэдээллийн хэрэгслээр нийтэлсэн. Энэхүү зарын дагуу нийт 19 нэр дэвшигч материалаа ирүүлсэн. Нэр дэвшигчдийн судалгаанаас эрх зүйч -3, инженер -6, санхүү, эдийн засгийн чиглэлээр мэргэшсэн 10 хүн материал ирүүлсэн байна.

Сонгон шалгаруулалтын зард тусгаснаар хараат бус гишүүнд нэр дэвшигч нь Компанийн тухай хуулийн 79.1-д зааснаас гадна холбогдох журамд заасан нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан байх, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хангалттай ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлагатай байх чадварууд дээр голчлон ажилласан.

Сонгон шалгаруулалтын журам, Компанийн тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй, материалын бүрдэл дутуу 6 нэр дэвшигчид эхний шатанд хасагдсан байна. Үлдсэн нэр дэвшигчдээс Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчилгүй, бизнесийн байгууллагын удирдах түвшинд ажиллаж, уул уурхайн томоохон төсөл хэрэгжүүлэхэд оролцож байсан, хангалттай ур чадвар, мэдлэг, боловсрол, ажлын туршлагатай, баримт бичиг, нийтлэг шаардлага хангасан дараах 4 нэр дэвшигч өндөр оноо авсан тул дараагийн ярилцлагын шатанд урьж оролцуулсан. Үүнд Х.Лхагвадорж, Ч.Энхтөр, Ш.Эрдэнэ, Г.Түвшинзаяа нар байна.

Сонгон шалгаруулалтын үнэлгээний дээд оноо 100 байх бөгөөд нийтлэг шаардлагыг оноо 10, тусгай шаардлагын оноо 60 хүртэл, ярилцлагын оноо 30 хүртэл онооны бүтэцтэй байна.

Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хамгийн өндөр оноо авсан 3 нэр дэвшигчийг та бүхэнд танилцуулж байна. Үүнд, Х.Лхагвадорж нийт 94 оноо, Ч.Энхтөр нийт 93 оноо, Ш.Эрдэнэ нийт 91 оноо тус тус авсан. Хараат бус гишүүн сонгон шалгаруулсан дүгнэлт, тайланг та бүхэнд уншиж танилцууллаа. Баярлалаа.

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Нэр дэвшүүлэх хорооны Л.Наранчимэг даргад баярлалаа. Ингээд хараат бус гишүүдийг "Шивээ-Овоо" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн Нэр дэвшүүлэх хорооны саналын дагуу Х.Лхагвадорж, Ч.Энхтөр, Ш.Эрдэнэ нарыг нэр дэвшүүлж, Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийг төлөөлж Ц.Төгсбуян, Д.Нямдэлгэр, Г.Даваажаргал, М.Мэндбаяр, Б.Төгөлдөр, Л.Наранчимэг нарыг нэр дэвшүүлж байна.

Ингээд хувьцаа эзэмшигчдийн зүгээс өнөөдөр танилцуулагдсан асуудлуудтай холбоотой асуулт, хариултыг эхлүүлж байна. Асуулт, хариултыг эхлүүлсэнтэй холбогдуулан Гүйцэтгэх захирал Г.Батсуурь, ТУЗ-ийн дарга Ц.Төгсбуян нарыг хамт суун, асуултад хариулахыг урьж байна. Дарааллын дагуу гар өргөсөн дарааллаар асуулт асууя.

Хувьцаа эзэмшигч /Отгонбаатар/:

Манай компани бол ашгийн төлөө буюу хувьцаат компани. Олон нийтийн хувьцаа эзэмшилтэй 1500 орчим хувьцаа эзэмшдэг хүмүүсийн хөрөнгийг удирддаг байгууллага. Тэгэхээр өнөөдөр хувьцаа эзэмшигч миний хувьд компани ашигтай ажиллахыг шаардана. Ашигтай ажилласны үндсэн дээр ногдол ашиг авахыг хүсэмжилнэ, шаардана. Энэ дагуу сууж байгаа. Би ойлгож байна. Өмнө нь ХЭХ-д би хэлж байсан үнийг өөрчлөх талаар. Яах аргагүй эрчим хүчний реформ хийгдэж байна. Үүнийг дагаад манай компани 1 тонн нүүрсний үнийг заавал нэмэгдүүлэх ёстой. Энийг ХЭХ-аас протокол дээр заавал оруулах ёстой. Тэгж байж энэ компани ашигтай ажиллана.

Үүнийг "Эрдэнэс Монгол" ХХК, эсвэл эрх зүйн байгууллагад нь өгөх санал юм шүү. 660мвт-ын цахилгаан станц барих асуудал хөндөгдөж байна. Станц барьж байж манай компани ашигтай байна шүү дээ. Станц дээр тендер зарлаад, сонгон шалгаруулалт яваад компани тодорчхоогүй юм уу? Энэ дээр тайлбар өгөөч. Бид нүүрсийг хэдэн төгрөгөөр өгч байж ашигтай ажиллана гэсэн үнийн таамаглал байна уу? Монгол улсын 3,4 дүгээр цахилгаан станц, Амгалангийн дулааны станц руу өгдөг шиг үнэ өгөхгүй байх гэж би найдаж, итгэж байна. Би энийг шаардана. Энэнээс өөр үнээр компанид ашигтай байх үнэ, гэрээ хэлцэл байна уу? Энэ дээр анхаараарай гэдэг санал, буюу асуулт асуумж юм шүү. Өрийг хувьцаагаар солих гээд жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хөндөхгүй байх бодлого баримталж байна гэж хэлж байна. Энэ туйлын зөв. Энэ өрийг хэн тавьчихсан юм. 10%-ийг эзэмшиж буй бид өр үүсгээгүй шүү дээ. Үе үеийн төрийн удирдлагын төрөөс томилогдсон этгээдүүд ажиллуулж байх хугацаандаа энэ байгууллагыг алдагдалтай ажиллуулсан. Хэрвээ өрөө хувьцаагаар солих бол 90 хувиасаа солих ёстой шүү. 10% руу нэг ширхгийг ч оруулах ёсгүй шүү. Энэ дээр хатуу байр суурьтай байна. Төрийн байгууллагууд өгөх ёстой байх. Энэ их мөнгө, мөнгийг бид оруулж, хөрөнгө оруулсан. Бодлогын чанартай анхаараасай гэж хүсэж байна.

Компанийн тухай хуулиар хараат бус гишүүн гэж маш чухал эрх зүйгээр зохицуулагдсан байдаг. Энэ компани ашигтай ажиллах, бидний эрх ашгийг хамгаалдаг. Тэгэхээр хараат бус гишүүнийг томилгоогоор биш байдлаар хандаач. ТУЗ-д орно гэдэг сайн дурын ажил биш. Хараат бус гишүүн ажиллах боломжийг нь олгооч.

Гүйцэтгэх захирал Г.Батсуурь:

Мэдээж компани ашигтай ажиллах ёстой санал нэг байна. Компанийн удирдлагууд бүгд шинэчлэгдээд ажилдаа ороод явж байна. Миний бие урьд нь Говьсүмбэр аймгийн Засаг даргаар ажиллаж байхад 3 ийм төсөл байсан юм. Уурхайг түшиглэсэн 3 станц барих төсөлтэй танилцаж байсан юм. Тэгээд 4 дэх дээр нь өөрөө энэ уурхай дээр ирж ажиллаж байна. Тэгээд энэ төслийг сонгон шалгаруулаагүй. Монгол Улсад гаднын хөрөнгө оруулалт орох хууль, ёс журмын дагуу орж ирж станц барих газраа авчихсан. ЭХЯ, хөрөнгө оруулагч, уурхай 3 хамтран санамж бичиг байгуулчихсан. Энэ хөрөнгө оруулагч ЭХЯ-тай эрчим хүч худалдах худалдан авах гэрээгээ баталгаажуулах юм. Бусад тусгай зөвшөөрлүүд бүгдийг нь хангачихсан. Энэ зөвшөөрлийг л авчих юм бол ажил нь жигдрээд явна гэсэн харилцан ойлголцолтой явж байна. Үнийн хувьд мэдээж тодорхой үнэ өгөөгүй. Мэдээж зах зээлийн ашигтай ажиллах тооцоолол хийж, үнэ санал болгоно. Энэ үнийг хийхийн тулд хөрөнгө оруулагч эхний ээлжид ЭХЯ-тай эрчим хүчээ ямар үнээр өгөх юм бэ гэдэг гэрээгээ л эцэслэх юм гэсэн. Тэр үнийн гэрээ

эцэслэгдчих юм бол бид үнэ тохирно гэсэн. Эхний санамж бичиг болон уулзалтаар ийм байдалтай байгааг та бүхэнд танилцуулъя.

ТУЗ-ийн дарга Ц.Төгсбуян:

Нэмэлт мэдээлэл өгье. Цахилгаан станцтай холбоотой 660мвт-ын цахилгаан станцыг Шивээ-Овоо уурхайн дэргэд байгуулахаар төлөвлөсөн. ТЭЗҮ ЭХЯ-ны шинжлэх ухааны зөвлөл батлагдчихсан. Тэгэхээр энэ ТЭЗҮ-ээр бид 1 тонн нүүрсээ 85 мянган төгрөгөөр буюу тодорхой хэмжээний маржинтай байхаар тусгуулсан юм. Тэгээд “Эрдэнэс Монгол” ХХК болон “Шивээ-Овоо” ХК-аас тариф тохирох ажил ЭХЯ дээр явагдаж байгаа. Бид ТУЗ дээр тусгасан үнээрээ аль болох нүүрсээ нийлүүлнэ. Энэ компани ашигтай ажиллах ёстой. Ашигтай ажилласнаараа та бүхэнд ногдол ашиг хуваарилах боломжийг хүртэнэ. Мөн түүнчлэн бид энэ шаардлагатай техник, нэмээд 3 сая тонн нүүрс жил тутам нийлүүлэх тооцоотой 661 Мвт 3 сая тонн гэдэг өөрөө хүчин чадлыг 1.5 дахин нэмж байгаа. Тэгэхээр бид техник, тоног төхөөрөмжийн шинэчлэл, өргөтгөл хийх шаардлагатай. Энийг бид хөрөнгө оруулагч талаасаа хамтарч шийдье, найдвартай нүүрс нийлүүлэх үүрэг хүлээе, шаардлагатай техник хангамжийн шинэчлэл, өргөтгөлийг хамтраад хийе гэдэг ийм байдлаар яриа хэлэлцээрүүд явагдаж байгаа гэдгийг та бүхэнд дуулгахад таатай байна.

Хараат бус гишүүдтэй холбоотой асуулт асууж байсан. Компанийн тухай хуулиараа манай нэр дэвшүүлэх хорооноос 4 сарын 14-нд нээлттэй сонгон шалгаруулалт зарласан. Энэнийхээ хүрээнд сонгон шалгаруулалтын дүнг нэр дэвшүүлэх хорооны дарга Л.Наранчимэг танилцууллаа. Тэгэхээр бид хараат бусаар үйл ажиллагааг нь хэрэгжүүлнэ. Үүнийг би өөрөө ТУЗ-ийн даргын хувиар хариуцлагатай мэдэгдэж байна. Мөн 90%-ийн хувьцаа эзэмшигч “Эрдэнэс Монгол” ХХК нь ч мөн адил ногдол ашиг авмаар байгаа. Үндэсний баялгийн сангийн тухай хуулиараа бид үндэсний баялгийн сандаа мөнгө төвлөрүүлмээр байгаа. Гэхдээ мэдээж эрчим хүчний реформ тодорхой хугацаанд хийгдээгүй байна. Эрчим хүчний үнэ чөлөөлөгдөөгүй байна. Үүнийг дагаад борлуулж буй бүтээгдэхүүн өртгөөсөө дор байгаад байна. Харин ч Эрдэнэс Монгол компанийн зүгээс тодорхой өр төлбөр барагдуулах шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлээд цаг тухай болгоноос энэ уурхайн тасралтгүй найдвартай үйл ажиллагааг хангах дээр анхаарч ажиллаж байгаа.

Төвийн эрчим хүчний системд нүүрс нийлүүлдэг Шивээ-Овоо уурхай зогсвол Улаанбаатар хот хөлдөх эрсдэлтэй аюултай. Тэгэхээр энийг манай жижиг хувьцаа эзэмшигч нар сайн ойлгож, хүндэтгэлтэй ханддагт бидний зүгээс талархалтай байна. Тэгээх бид цахилгаан станц барья, хажуудаа нэмж бүтээгдэхүүн үйлдвэрлэе, тэрэндээ ядаж ашигтай заръя, тэгээд ашигтай ажиллагаагаа нэмээд ногдол ашиг төлдөг болъё гэдэг ийм бодлогыг бариад, тодорхой үр дүн гаргаад явж байна. Баярлалаа.

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Би “Эрдэнэс Монгол” ХХК-ийн Санхүүгийн нэгдсэн удирдлагын газрыг хариуцан ажиллаж байна. Өрийг хувьцаагаар солих асуудлыг өнөөдөр танилцуулж, та бүхний сонорт хүргээд, хувьцаа эзэмшигчид тэмдэглэлд өөрсдийн санаа бодлыг тусгах нь зүйтэй гэж байгааг дэмжиж байна. Та бүгд өнөөдрийн хэлэлцүүлсэн асуудалд ямар санаа бодолтой байгааг талаар мэдээлэл авч, цаашид энэ ажлыг хийх ямар хувилбарууд байна гэдгийг судалж үзэхэд хэрэгтэй. Тэгэхээр мэдээж тэмдэглэлд тусгана. Бүгд хувьцаа эзэмшигч учраас бид бүгд ногдол ашигтай ажиллах, ногдол ашиг авахын төлөө ажиллана. Энэ өрийн асуудлыг шийдэж, дараа нь нүүрсний үнийн асуудлыг гүйцэтгэх удирдлага, компанийн зүгээс, Эрдэнэс Монгол компанийн зүгээс ч ЗГ, Ерөнхий сайд, ЗГХЭГ дарга зэрэг бүх шатны удирдлагуудад удаа дараа асуудлыг тавьж, явж байгаа. Тэгэхээр энэ асуудал шийдвэрлэгдэх байх гэж найдаж байна.

Хувьцаа эзэмшигч /Даваадолгор/:

Сая танилцуулгаас сонсохоор асуудлыг дотооддоо судалж, үзэж ажил эхлүүлэх юм байна гэж ойлгогдсон. Энэ санал авах хуудсанд зөвшөөрсөн, татгалзсан гээд хэлэлцэх асуудалд ороод явчихаар компанийн өрийг хувьцаагаар солих тухай гээд үүнийг зөвшөөрсөн гээд ХЭХ-аар баталчихаар энэ ажил өөрөө шууд автоматаар явагдах болчихоод байна шүү дээ. Энэ асуудал маш эргэлзээтэй бүрхэг харагдаад байна.

Тооллогын комиссын дарга:

Уучлаарай тодруулга өгье. 2026 оны 3 сарын 19-ний өдөр ТУЗ хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулахаар зарласан. Хурал зарлахад 6 асуудал хэлэлцэхээр тогтоолын

төсөл боловсруулагдсан. Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар өрийг хувьцаагаар солих болон компанийн өрийг хувьцаагаар солих асуудал, компанийн дүрмийн өөрчлөлт оруулах 2 асуудал хойшлогдсон. Тэгэхээр тэрхүү саналын хуудасны хүснэгт дээр (Х) эсвэл (-) гэж тэмдэглээд, санал өгөхгүй байж болно. Харин үлдэж буй 4 асуудлаар Та бүхэн санал өгнө.

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Тэгэхээр энэ удаа ЗГ-аас гарсан тогтоолын дагуу компани судалгаагаа хийгээд асуудлыг дахин ХЭХ-аар оруулж ирж, шийдвэрлүүлэх гэсэн агуулгатай тогтоолын төслийг боловсруулсан байгаа. Тэгэхээр тогтоолын төслийг дэмжих, үгүй гэдэг саналд зөвшөөрсөн эсвэл татгалзсан гэж тэмдэглэх юм. Тэгэхээр тооллогын комисс сая санал өгөх зааврыг танилцууллаа.

Хувьцаа эзэмшигч /БиДиСек ҮЦК-аас төлөөлж ирсэн Онон/:

Саналын хуудас дээр зөвшөөрсөн, татгалзсан гэсэн 2 сонголт өгсөн байна. Тэгэхээр дүрмийн хувьд зөвшөөрсөн, татгалзсан, түдгэлзсэн гэдэг 3 сонголт бидэнд өгөх ёстой. Тэгвэл энэ удаагийн 4, 5 дугаар хэлэлцэх асуудлын дагуу бид түдгэлзэх гэдэг сонголтыг сонгохоор автоматаар энэ асуудлыг хойшлуулах байдлаар шийдвэр гарна гэсэн саналтай байна. Тэгвэл хурлын тогтоол, тайлбар маш тодорхой болох юм.

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Санал хэллээ. Тооллогын комисс санал хураах хуудасны заавар, танилцуулгыг өгье.

Хувьцаа эзэмшигч:

Үйлдвэрийн захиргааны орон тоо, зардал өндөр байна гэж харлаа. Их цалинтай захиргааны ажилтан ихтэй байгууллага юм байна гэж дүгнэлээ. Орон тоог багасгаж ажиллавал яасан юм бэ? Тэгж байж цалингийн зардал гэх мэт зардлууд буурна шүү дээ. Орон тоо гэдэг хамгийн чухал. Бид улсад ажиллаж байсан хүмүүс мэднэ. Тэгээд нэг их олон дарга орж ирээд суучихдаг. Ажил хийж байгаа хүүхдийн цалин нь бага, эндээс л зардал өндөр болоо байлгүй дээ. Орон тоог аль болох багасгах нь зүгээр юм уу гэж ажиглалаа.

Гүйцэтгэх захирал Г.Батсуурь:

Тантай санал нэг байна. 2026 онд бид бүхэн удирдах ажилтны бүтцийг ТУЗ-өөрөө батлуулсан. Үүнд олон дэд захирал, менежер гэсэн бүтцийг бүгдийг нь цомхотгосон. Одоо гүйцэтгэх захирал, ерөнхий инженер гээд мэргэжлийн албад, хэлтсүүд байгаа учраас захиргааны орон тоог багасан. Тэрийг дараагийн тайланд тодорхой харуулж, хариулна.

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Өөр асуулттай хүн байхгүй байна. Тэгэхээр хэсэг хугацаанд завсарлаад эргээд тооллогын комиссын тогтоолтой танилцъя.

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Тооллогын комиссын дарга тогтоолыг танилцуулна.

Тооллогын комиссын дарга:

Тооллогын комисс дүнг нэгтгэн гаргалаа. Тооллогын комисс 6 асуудлаар тогтоол гаргаж байна. Үүнд:

1. “Шивээ-Овоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд ирвэл зохих 13,419,101 ширхэг хувьцаа эзэмшдэг 1,596 хувьцаа эзэмшигчдээс брокерын пүүсүүдээр дамжуулан хуралд оролцох санал 0 ирсэн байна. Төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлэгч “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 90% буюу 12,077,191 ширхэг хувьцааны эрхтэй, бусад хувьцаа эзэмшигчдийг төлөөлж 12 хүн итгэмжлэлээр, 54 хувьцаа эзэмшигч өөрийн биеэр ирж, нийт 13,252,300 ширхэг хувьцаатай 65 хувьцаа эзэмшигчид хуралд оролцож, хурлын ирц 98.7570 хувьтай байна.
2. “Шивээ-Овоо” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай тогтоолд 61 хувьцаа эзэмшигч 13,252,185 санал буюу 100 хувийн саналаар дэмжсэн байна.

3. “Шивээ-Овоо” ХК-ийн 2025 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай тогтоолд 61 хувьцаа эзэмшигч 13,252,185 санал буюу 100 хувийн саналаар дэмжсэн байна.
4. Компанийн өрийг хувьцаагаар солих тухай асуудлыг хэлэлцэж, Компанийн өрийг хувьцаагаар солих арга хэмжээний тухай тогтоолыг дэмжсэн 25 хувьцаа эзэмшигчийн 12,077,944 ширхэг хувьцаа буюу 91.14 хувь, татгалзсан 36 хувьцаа эзэмшигчийн 1,174,241 ширхэг хувьцаа буюу 8.86 хувийн саналыг тус тус өгч, олонхын саналаар дэмжигдсэн байна.
5. Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж, компанийн дүрэмж өөрчлөлт оруулах тухай тогтоолыг дэмжсэн 45 хувьцаа эзэмшигчийн 12,078,525 санал буюу 91.14 хувь, татгалзсан 16 хувьцаа эзэмшигчийн 1,173,660 санал буюу 8.86 хувийн саналыг тус тус өгч, олонхын саналаар дэмжигдсэн.
6. “Шивээ-Овоо” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг томилох сонгох санал хураалт явуулж, олонхыг санал авсан дараах хүмүүсийг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдээр батлахыг Хувьцаа эзэмшигчдийн хуралд уламжилж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох санал хураалтыг кумулятив аргаар санал хураасан. Кумулятив арга нь санал өгөх эрхийн нийт тоо таны эзэмшиж байгаа саналын эрхтэй энгийн хувьцааны тоог сонгогдох гишүүний тоогоор үржүүлсэнтэй тэнцүү байхаар зохицуулагдсан байдаг. Ингээд саналыг танилцуулъя. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Ц.Төгсбуян 12,512,598 санал буюу 10.49 хувь, Д.Нямдэлгэр 12,512,580 санал буюу 10.49 хувь, Г.Даваажаргал 12,512,946 санал буюу 10.49 хувь, М.Мэндбаяр 12,512,763 санал буюу 10.49 хувь, Б.Төгөлдөр 12,512,763 санал буюу 10.49 хувь, Л.Наранчимэг 12,512,580 санал буюу 10.49 хувь, Хараат бус гишүүнээр Х.Лхагвадорж 16,141,216 санал буюу 13.53 хувь, Ч.Энхтөр 15,538,953 санал буюу 13.03 хувь, Ш.Эрдэнэ 12,513,266 санал буюу 10.49 хувийн санал тус тус авч ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүнээр сонгогдох болзлыг хангасан байна.

Ийнхүү тооллогын комисс 6 тогтоолын төслийг батлан тусгаж, Хувьцаа эзэмшигчид болон хурлын даргад танилцуулж байна.

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Тооллогын комиссын тогтоолыг танилцуулсанд баярлалаа. Өнөөдрийн ХЭХ-аас гарах тогтоолын төслүүдийг уншиж, танилцуулаад, албажуулъя.

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг хэлэлцэж:

“ШИВЭЭ-ОВОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны үйл ажиллагааны
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс
гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн ТОГТООХ нь:

1. “Шивээ-Овоо” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, “Хангалттай” гэж баталсугай.

2. “Шивээ-Овоо” ХК 2026 онд компанийн үйлдвэрлэлийн зорилтот түвшний биелэлтийг хангах, санхүү эдийн засгийн хувьд ашигтай ажиллах, өр авлагыг багасгах, өсөн нэмэгдэж байгаа эрчим хүчний эрэлттэй уялдуулан үйлдвэрлэлийн найдвартай хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Төгсбуян), Гүйцэтгэх захирал (Г.Батсуурь)-д

үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ,
“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН
САНХҮҮГИЙН НЭГДСЭН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЗОРИГТБАТ

2. Компанийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг батлах тухай асуудлыг хэлэлцэж:

“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Компанийн 2025 оны санхүүгийн
тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс
гаргасан дүгнэлтийг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9, “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн ТОГТООХ нь:

1.“Шивээ-Овоо” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлөөс гаргасан дүгнэлтийг хэлэлцэж, “Сайжруулах шаардлагатай” гэж баталсугай.

2.“Шивээ-Овоо” ХК-ийн 2026 оны батлагдсан бизнес төлөвлөгөөний хүрээнд үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, компанийн үр ашгийг нэмэгдүүлэн, эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг хангаж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Төгсбуйан), Гүйцэтгэх захирал (Г.Батсуурь)-д үүрэг болгосугай.

3.Үндэсний Аудитын газрын 2025 оны санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Батсуурь)-д даалгасугай

ХУРАЛ ДАРГАЛАГЧ,
“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН
САНХҮҮГИЙН НЭГДСЭН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЗОРИГТБАТ

4.Компанийн өрийг хувьцаагаар солих тухай асуудлыг хэлэлцэж:

“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Компанийн өрийг хувьцаагаар солих арга
хэмжээний тухай

Компанийн тухай хуулийн 25 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.3, 63 дугаар зүйлийн 63.7, “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 157 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 27 дугаар хурлын тэмдэглэл, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 04 дугаар тогтоолыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар

хэлэлцэн ТОГТООХ нь:

1.Компанийн өөрийн хөрөнгийн хэмжээ нь хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнээс багассаныг харгалзан үзэж, “Эрдэнэс Монгол” ХХК-д төлөх өрийг барагдуулах хүрээнд хувьцаагаар солих асуудлыг судалж, холбогдох саналыг хууль, тогтоомжид нийцүүлэн дахин боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Төгсбуян), Гүйцэтгэх захирал (Г.Батсуурь)-д тус тус даалгасугай.

2.Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, шаардлагатай бусад арга хэмжээг авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Г.Батсуурь)-д зөвшөөрсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ,
“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН
САНХҮҮГИЙН НЭГДСЭН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЗОРИГТБАТ

5.Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэж:

“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай

Компанийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 59 дүгээр зүйлийн 59.1, 62 дугаар зүйлийн 62.1.15, “Шивээ-Овоо” ХК-ийн дүрмийн 3.2 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн ТОГТООХ нь:

Компанийн өрийг барагдуулах хүрээнд хувьцаагаар солих асуудлыг судалж, холбогдох саналыг хууль, тогтоомжид нийцүүлэн дахин боловсруулж, хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар шийдвэрлүүлэхээр тогтоосонтой холбогдуулан “Шивээ-Овоо” ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлыг энэ удаагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангаж, хувьцаа эзэмшигчдэд холбогдох мэдээллийг хууль, тогтоомжид нийцүүлэн хүргэж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөл (Ц.Төгсбуян)-д үүрэг болгосугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ,
“ЭРДЭНЭС МОНГОЛ” ХХК-ИЙН
САНХҮҮГИЙН НЭГДСЭН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЗОРИГТБАТ

7. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай асуудлыг хэлэлцэж:

“ШИВЭЭ-ОВОО”
ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2026 оны 04 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг
томилох тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, "Шивээ-Овоо" ХК-ийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2.1 дэх заалт, хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэн ТОГТООХ нь:

1. "Шивээ-Овоо" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон, хараат бус гишүүдээр дараах нэр дэвшигчдийг томилсугай.

1.1. Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчийг төлөөлж:

- 1.1.1. Ц.Төгсбуян
- 1.1.2. Д.Нямдэлгэр
- 1.1.3. Г.Даваажаргал
- 1.1.4. М.Мэндбаяр
- 1.1.5. Б.Төгөлдөр
- 1.1.6. Л.Наранчимэг

1.2. Хараат бус гишүүнээр:

- 1.2.1. Х.Лхагвадорж
- 1.2.2. Ч.Энхтөр
- 1.2.3. Ш.Эрдэнэ

2. "Шивээ-Овоо" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг эрх бүхий байгууллагаас нэр дэвшигчдийг хувийн ашиг сонирхлын зөрчилгүй болохыг тогтоосон өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр тогтоосугай.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ,
"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК-ИЙН
САНХҮҮГИЙН НЭГДСЭН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ЗОРИГТБАТ

Хурал даргалагч Ц.Зоригтбат:

Өнөөдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцсэн асуудлуудаар танилцуулсан тогтоолууд бүгд батлагдаж байгааг зарлая. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал үүгээр өндөрлөж байгааг мэдэгдье. Хүрэлцэн ирсэн бүх хувьцаа эзэмшигчид, компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх захирал, гүйцэтгэх удирдлагын багт талархал илэрхийлье. Баярлалаа.

"Шивээ Овоо" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хаасныг мэдэгдэж байна.

"Шивээ Овоо" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 13 цаг 22 минутад дуусав

ХУРАЛ ДАРГАЛАГЧ,
"ЭРДЭНЭС МОНГОЛ" ХХК-ИЙН
САНХҮҮГИЙН НЭГДСЭН УДИРДЛАГЫН
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ЗОРИГТБАТ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.СОЛОНГО